

Эрдэнэ Ресурс нь Баян Хөндий Төслийн талбайд өндөр агуулга бүхий алтны эрдэсжилтийг огтолж, нөөцийг тэлэх боломжтойг харууллаа

Хэвлэлийн мэдээ

Нова Скошиа муж, Халифакс хот
2020.10.01

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX:ERD | MSE:ERDN) (“Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани”) нь Хөндий Алтны Дүүрэгт гүйцэтгэсэн 18,000 тууш метрийн өрөмдлөгийн хөтөлбөрийн анхан шатны үр дүнг танилцуулж байгаадаа таатай байна.

Онцлох мэдээлэл:

- Баян Хөндий тусгай зөвшөөрлийн талбайд 10,000 метр бүхий 1-р үе шатны өрөмдлөгийг гүйцэтгэв:
 - Баян Хөндийд 8,435 метрийн 4 өргөтгөлийн цооногийг хамарсан 45 цооног өрөмдсөн.
 - Хар Морь талбайд 1,754 метрийн 11 цооног өрөмдсөн.
- Баян Хөндийд өрөмдсөн 12 өргөтгөлийн цооног (2,016 метр)-ийн үр дүнгүүдэд:
 - Хойд Мидфийлд: Төлөвлөсөн уурхайн хананаас зүүн болон баруун зүгт өргөтгөлийн өрөмдлөг гүйцэтгэн, өндөр агуулга бүхий эрдэсжсэн интервалыг огтолсон:
 - VKD-302 - Зүүн залгаа өргөтгөл: Цооногийн 127 метрийн гүнээс эхлэн (босоогоор 115 метр) 27.5 г/т алтны агуулга бүхий 2 метр агуулсан 3.9 г/т алтны агуулга бүхий 22.4 метр интервалыг төлөвлөсөн уурхайн ханатай зүүн зүгт залгаа бүсэд огтолсон.
 - VKD-304 - Баруун залгаа өргөтгөл: Цооногийн 206 метрийн гүнээс эхлэн (босоогоор 144 метр) 38.9 г/т алтны агуулга бүхий 1 метр агуулсан 3.9 г/т алтны агуулга бүхий 12 метрийн интервалыг төлөвлөсөн уурхайн ханатай баруун зүгт залгаа бүсэд огтолсон.
 - Баруун өмнөд Страйкер: Төлөвлөсөн уурхайн хананаас өмнөд зүгт өндөр агуулга бүхий эрдэсжсэн бүсийг тэлсэн:
 - VKD-310 – Цооногийн 14 метрийн гүнээс эхлэн 24.5 г/т алтны агуулга бүхий 1 метр агуулсан 4.0 г/т алтны агуулга бүхий 10 метрийн интервал, цооногийн 64 метрийн гүнээс эхлэн 16.2 г/т алтны агуулга бүхий 1 метр агуулсан 1.0 г/т алтны агуулга бүхий 44 метрийн интервал огтолсон.
 - VKD-312 – Цооногийн 13 метрийн гүнээс эхлэн 51.7 г/т алтны агуулга бүхий 1 метр агуулсан 20.8 г/т алтны агуулгатай 3 метрийн интервал огтолсон.
- Баруун өмнөд Мидфийлд, Баруун Страйкер, Зүүн хойд Баян Хөндий болон Хар Морь талбайд хийсэн 7,945 метрийн 48 цооногийн сорьцлолтын үр дүнгүүд хүлээгдэж байна.
 - 10 цооногт нүдэнд үзэгдэх алт илэрсэн. (Доорх мэдээлэлтэй танилцана уу)

Тодруулга:

Компанийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Петер Акерли хэлэхдээ: “2020 оны 1-р үе шатны өрөмдлөгийн хөтөлбөрөөр хэд хэдэн өндөр агуулга бүхий цооног огтолж, Баян Хөндий Алтны Төслийн төлөвлөсөн уурхайн хананы захад 10 өрмийн цооногт нүдэнд үзэгдэх алт илрүүлсэн бөгөөд тэдгээрийн үр дүнг хүлээж байна. Эдгээр

үр дүн нь 2020 оны 8-р сард танилцуулсан нарийвчилсан ТЭЗҮ-д тусгасан Баян Хөндий Алтны Төслийн нөөцийг тэлэх боломжтойг харуулж байна.”

“2020 оны 2-р үе шатны өрөмдлөгийн хөтөлбөрөөр Баян Хөндий, Алтан Нарыг тэлэх өрөмдлөгүүд болон Хар Морь, Алтан Сум, Улаан талбайд хайгуулын өрөмдлөг хийгдэхээр төлөвлөсөн. Бидэнд 2022 онд Баян Хөндий Алтны төслийн олборлолт эхлэхээс өмнө компанийн төслүүдийн нийт нөөцийг нэмэгдүүлэх олон хайгуулын боломжит талбайнууд бий” хэмээн танилцууллаа.

Өрөмдлөгийн хөтөлбөрийн онцлох мэдээлэл ба төлөвлөгөө

[Хавсралт зурагтай танилцана уу]

Компани нь Хөндий Алтны Дүүрэгт нийт 18,000 метрийн өрөмдлөгийн хөтөлбөрийг танилцуулснаас нэгдүгээр үе шат буюу 10,000 метрийн өрөмдлөгийн хөтөлбөрийг гүйцэтгээд байна. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь:

1. Баян Хөндийн нөөцийг тэлэх:
 - a. Хойд Мидфийлд, Зүүн өмнөд Мифдийлд, Баруун өмнөд Страйкер бүсүүдийн төлөвлөсөн уурхайн хананаас гадна хүдэр оршиж буйг баталгаажуулж, бүсүүдийг тэлэх,
 - b. Ил уурхайн тэлэлт болох боломжтой Баруун Страйкер бүсийн нөөцийн ангиллыг нэмэгдүүлж, нөөцийг тодорхойлох,
2. Баян Хөндий ордын хойд болон зүүн хойд бүс, Хар Морь, Алтан Сум болон Улаан талбайд шинэ нөөцийг илрүүлэх,
3. Төлөвлөгдсөн ил уурхай болон боловсруулах үйлдвэрийн талбайд нөөцийн ангилал ахиулах өрөмдлөгийн анхан шатны хөтөлбөрийг эцэслэх,
4. Алтан Нар алтны ордын трендийн дагуу тэлэлт болон хайгуулын өрөмдлөг хийхэд оршино.

Баян Хөндийн ордын нөөцийн тэлэлтийн боломжуудыг судлах үед Хойд Мидфийлд, Зүүн өмнөд Мидфийлд, Баруун өмнөд Страйкер бүсүүдийн өрмийн дээжинд нүдэнд үзэгдэх алт илэрсэн нь Баян Хөндий алтны төслийн хэмжээ болон эдийн засгийн өгөөжид эерэг нөлөө үзүүлнэ.

Баян Хөндий алтны орд: Төлөвлөсөн уурхайн хананаас гадуурх тэлэлт

Гүйцэтгэсэн өрөмдлөгийн хөтөлбөр нь ил уурхайн өнөөгийн хязгаараас гадна нөөцийг тэлэх, геологийн нөөцийг үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэх боломжтой юм. Баян Хөндийн нарийвчилсан ТЭЗҮ-д төлөвлөгдсөн ил уурхай нь 3.7 г/т алтны агуулга бүхий 409,000 унц алтны нөөц агуулж байгаа боловч төлөвлөсөн ил уурхайн залгаа орших талбайд ихээхэн нөөц агуулагдаж байна. Геологийн болон үйлдвэрлэлийн нөөц: 3.2 г/т алтны агуулга бүхий 521,000 баттай & бодитой нөөц, 3.7 г/т алтны агуулга бүхий 103,000 боломжит нөөц агуулагдаж байна. Эдгээр бүсүүдийн үргэлжлэл, агуулга, алтны үнэ өсөн нэмэгдэж буй өнөөгийн зах зээлийн нөхцөлд цаашид нэмэгдэх боломжтой бөгөөд хөгжүүлэлтийн шатаас алтны олборлолтыг эхлүүлэхэд шинэчилсэн ил уурхайд хамрагдах боломжтой. Одоогийн ил уурхайн хязгаартай залгаа орших хэд хэдэн алтны эрдэсжсэн бүсүүд нь маш өндөр агуулга бүхий (30-150 г/т алтны агуулга бүхий 1 метрийн интервалууд) алт агуулсан судлууд болон эрдэсжсэн өргөн интервалуудыг агуулж байна. Түүнээс гадна Баян Хөндий нөөц нь одоогийн ил уурхайн нөөцөөр хязгаарлагдсан бөгөөд урьд нь хийгдсэн өрөмдлөгийн хөтөлбөрөөр алтны эрдэсжсэн бүсүүдийг огтолсон нь цаашид нэмэлт хайгуулын өрөмдлөг хийгдэх шаардлагатай. Энэхүү өрөмдлөгийн хөтөлбөрөөр шалгасан бүсүүдийн тухай доор танилцууллаа.

Хойд Мидфийлд

Хойд Мидфийлд нь Баян Хөндий ордын хамгийн хойд бүс юм. Гүйцэтгэсэн өрөмдлөгийн хөтөлбөрөөр төлөвлөсөн уурхайн хязгаараас гадна алтны эрдэсжилт үргэлжилж байгааг шалгах 5 (BKD-301 – BKD-305) өрөмдлөгийг хийж гүйцэтгэсэн. Өрөмдлөг хийсэн эдгээр бүс нь одоогийн уурхайн хананаас гадна тэлж буй

өндөр агуулга бүхий бүсүүдийн үргэлжлэлийг шалгахад оршино. 5 цооногоос 4 цооногт төлөвлөсөн ил уурхайн хязгаараас гадна аномаль эрдэсжсэн алт (≥ 0.2 г/т алт) илэрсэн.

Эдгээрээс хоёр цооногт (BKD-302 ба BKD-304) төлөвлөсөн ил уурхайн хязгаараас гадна өндөр агуулга бүхий алтны эрдэсжилтийг огтолсон. Хойд Мидфийлд бүсийн зүүн хэсэгт өрөмдсөн BKD-302 цооногт: 3.9 г/т алтны агуулга бүхий 22.4 метрийн интервал огтолсон бөгөөд үргэлжлүүлэн дунджаар 0.38 г/т алтны агуулга бүхий 39 метрийн эрдэсжсэн өргөн интервал огтолсон. Цооног хоорондын зай BKD-302 цооногийн баруун, зүүн зүгт харьцангуй өргөн байгаа нь өндөр агуулга бүхий бүс тэлэх боломжтойг харуулж байна. Хойд Мидфийлд бүсийн баруун зүгт өрөмдсөн BKD-304 цооног нь 38.5 г/т алтны агуулга бүхий 1 метр агуулсан 3.9 г/т алтны агуулга бүхий 12 метрийн интервал огтолсон бөгөөд энэхүү интервал нь төлөвлөсөн уурхайн хязгаараас гадна, гүнд байрлаж байна. BKD-302, BKD-304 цооногууд нь төлөвлөгдсөн ил уурхайн хязгаараас гадна одоогийн агуулгатай төстэй өндөр агуулга бүхий бүсүүд үргэлжлэх боломжтойг харууллаа. Энэхүү бүсүүдийг үргэлжлүүлэн судалж, тодорхойлсноор Баян Хөндийн олборлох боломжтой үйлдвэрлэлийн нөөцөд эерэгээр нөлөөлж, эдгээр шинэ тэлэлтийн бүсүүд дээр тулгуурлан уурхайн хязгаарыг тэлэх боломжтой.

Цооног	-ээс (метр)	Хүртэл (метр)	Интервал (метр)*	Алтны агуулга (г/т)
BKD-301	87.9	170	82.1	0.60
түүнд	107	139	32	1.17
түүнд	108	109	1	21.15
BKD-302	126.6	149	22.4	3.90
түүнд	126.6	140	13.4	6.02
түүнд	133	135	2	27.50
ба	161	200	39	0.38
түүнд	162	177	15	0.62
BKD-303	Ач холбогдол бүхий эрдэсжилт илрээгүй			
BKD-304	119.2	132	12.8	1.30
ба	142	196	54	0.56
түүнд	144	159	15	1.35
ба	206	218	12	3.87
түүнд	210	211	1	38.56
BKD-305	148.5	176	27.5	0.23
ба	200	203	3	1.81

Баруун Өмнөд Страйкер

Төлөвлөсөн уурхайн хязгаарын дотор болон гадна, өмнө зүгт хэд хэдэн цооног өрөмдсөн. Эдгээр цооногт хүчтэй кварцын штокверк, кварцын гематит болон кварцын адуляр судлуудыг огтолсон ба нүдэнд үзэгдэх алт илэрсэн. Доорх хүснэгтээр зарим цооногийн үр дүнгүүдийг (BKD-311 хүртэл болон BKD-312 цооногийн дээд үзүүр) танилцуулсан бөгөөд одоогийн нөөцийн хязгаараас үргэлжлэн төлөвлөсөн уурхайгаас өмнө зүгт газрын дөт гүнд өндөр агуулга бүхий эрдэсжилтийг баталлаа. BKD-312 цооногийн анхан шатны үр дүнгээс газрын гүнээс 10 метрт 20.8 г/т алтны агуулга бүхий 3 метрийн интервал огтолсон нь газрын дөт гүнд өндөр агуулга бүхий алтны эрдэсжилт байгааг илэрхийлж байна.

*Тайлагнасан интервал нь цооногийн огтлолын зузаан болно. Өрөмдлөгийн цооногууд нь баруун өмнөд унал, баруун хойд баруун алтны судлыг огтлохоор чиглэсэн байсан тул мэдээлсэн зузаан нь бодит зузаантай маш ойрхон байна. Гэвч BKD-312 цооногийн ойр орших геологийн үзүүлэлтүүд нь энэхүү цооногийн дотоод судлын чиглэлд нөлөөлөх боломжтой. Үүнийг батлахын тулд нэмэлт судалгаа хийх шаардлагатай.

Баруун өмнөд Страйкер бүсийн анхан шатны үр дүнг доорх хүснэгтээр харуулсан бөгөөд хэд хэдэн дээжийн үр дүн хүлээгдэж байна. Эдгээр үр дүнгүүд нь уурхайн хязгаарыг өндөр агуулгатай эрдэсжилт бүхий бүсээр хүрээлэн, баруун ба баруун өмнөд зүгт уурхайн хязгаарыг тэлэх боломжтойг харууллаа.

Цооног	-ээс (метр)	Хүртэл (метр)	Интервал (метр)*	Алтны агуулга (г/т)
BKD-306	48	53	5	0.32
ба	138	161	23	0.50
BKD-307	8	12	4	1.77
ба	68	88	20	0.29
BKD-308	56	60	4	0.36
ба	66	69	3	0.31
ба	83	94	11	0.31
ба	100	103	3	0.40
ба	153	156	3	0.68
BKD-309	Эрдэсжилт илрээгүй			
BKD-310	10.7	30	19.3	2.33
түүнд	14	24	10	4.02
түүнд	14	15	1	24.52
ба	64	108	44	1.01
түүнд	66	68	2	16.15
BKD-311	28	37	9	0.66
ба	107	124	17	0.34
BKD-312 ¹	13	16	3	20.79
түүнд	14	15	1	51.70

Зүүн Өмнөд Мидфийлд (MFSE)

2020 оны 2-р улиралд гүйцэтгэсэн өрөмдлөгийн хөтөлбөрөөр Зүүн өмнөд Мидфийлд бүсэд газрын дөт гүнд маш өндөр агуулга бүхий бүсүүдийг нээн илрүүлсэн. Үүнд: BKD-288 цооногт 11.5 метрийн гүнд 581.6 г/т алтны агуулга бүхий 1 метрийн интервал агуулсан 125.9 г/т алтны агуулга бүхий 5.5 метрийн интервал огтолсон. BKD-274 цооногт 14.9 метрийн гүнд 338 г/т алтны агуулга бүхий 1 метрийн интервал агуулсан 25.6 г/т алтны агуулга бүхий 25 метрийн интервал огтолсон. 18 цооногийн 16-д нь алтны аномаль эрдэсжилт (≥ 0.2 г/т алт) огтолсон бөгөөд эдгээр нь бүгд газрын гадаргаас 25 метрийн гүнд багтсан. Энэхүү нээлтийг баруун хойш чиглэлтэй кварц-адулярын бүлэг судлууд, хойш-урагш чиглэлтэй таамаглаж буй тэжээгч структурын огтлол хэмээн тайлсан. Зүүн өмнөд Мидфийлд бүсийн структур нь суналын дагуу хамгийн багадаа 200 метр үргэлжилж байгааг тодорхойлсон боловч 2-р улирлын өрөмдлөгийн хөтөлбөрөөр хойд зүгт 50 метрийг шалгасан.

Гүйцэтгэсэн өрөмдлөгийн хөтөлбөрөөр зүүн өмнөд Мидфийлд бүсэд найман цооног өрөмдсөн бөгөөд зүүн өмнөд зүгт тэжээгч структур нь үргэлжилж байгааг шалгах зорилготой. Хэдийгээр үр дүн нь хүлээгдэж байгаа боловч найман цооногийн дөрвөн цооногт нүдэнд үзэгдэх алт илэрсэн. Энэ нь кварцын адулярын судал, гематит брекч болон барьцалдуулагчид агуулагдсан кварцын судлын материалтай холбоотой. Бусад цооногт Баян Хөндий системийн алтны эрдэсжилтийн үзүүлэлт болох кварц гематит ба цагаан гялтгануур судал бүхий

¹ BKD-12 цооногийн дээжлэлтийн бүрэн үр дүн болон алтны шигшүүрийн шинжилгээний үр дүнгүүд хүлээгдэж байна

интервалыг агуулсан. Эдгээр анхан шатны бүртгэлийн үр дүнгүүд нь Зүүн Өмнөд Мидфийлдийг Баян Хөндий орддын шинэ сонирхолтой бүс болохыг баталж байгаа ч өндөр агуулгатай алтны эрдэсжилт нь тэжээгч бүстэй холбоотой эсэхийг тодорхойлох шаардлагатай. Өнөөгийн нөөцийн тооцоололд хаягдал эсвэл бага агуулга бүхий овоолгын материалд ангилсан энэхүү бүс нь олборлолтын эхэн үед эдийн засгийн эерэг нөлөөлөл үзүүлэх боломжтойг баталлаа.

Баруун Страйкер

Баян Хөндий ил уурхайн төлөвлөсөн хананаас баруун зүгт 210 метрт оршдог Баруун Страйкер талбайд уурхайн хязгаараас гадна хамгийн том нөөц оршиж байна. 2019 оны 2-р улиралд өрөмдлөгийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, өнөөг хүртэл талбайд тодорхойлсон хамгийн өндөр агуулга буюу 136 метрийн босоо гүнд 40 г/т алтны агуулга бүхий 3 метрийн интервал огтолсон (BKD-265). BKD-265 цооногоор мөн дөт гүнд эрдэсжсэн бүс үргэлжилж байгааг тодорхойлсон, үүнд: 28 метр гүнд 2.7 г/т алтны агуулга бүхий 5 метрийн интервал агуулсан 1.1 г/т алтны агуулга бүхий 16 метрийн интервал илрүүлсэн. 2019 оны 2-р улиралд төлөвлөсөн уурхайн хананаас баруун хойд зүгт 250 метрт одоогийн нөөцийн хязгаараас гадна BKD-266 цооногийг өрөмдсөн. Энэхүү цооногоор 264 метрийн гүнд 51.9 г/т өндөр алтны агуулга бүхий 1 метрийн интервал огтолж цахиур-иллит ба магнетитийн хувиралд орсон галт уулын чулуулгийн өргөн бүсийг огтолсон нь Баян Хөндийн уурхайн одоогийн тодорхойлсон өндөр агуулга бүхий эрдэсжилтийн үргэлжлэл болон доош сунасан байх боломжтойг харуулсан.

Баруун Страйкер талбайд хийгдсэн нэгдүгээр үе шатны өрөмдлөгийн хөтөлбөрөөр Баруун Страйкер бүсийн цөмд орших нөөцийн тодорхойлолт гаргах, одоогийн мэдэгдэж буй алтны эрдэсжилтийн гадна нөөцийг тэлэх боломжтойг шалгахад 14 цооног өрөмдсөн. Хэдийгээр үр дүнгүүд хүлээгдэж байгаа ч бүртгэлийн явцад кварц адуляр болон кварц гематитийн судал бүхий өргөн интервалтай холбоотойгоор нүдэнд үзэгдэх алт илэрсэн.

Хар Морь

Баян Хөндий ордоос зүүн хойш 3.5 км-т, Алтан Сум талбайтай залгаа оршдог Хар Морь талбайд нэгдүгээр үе шатны хөтөлбөр хэрэгжүүлсэн. Хар Морь нь 1.5км х 3км талбайг хамрах бөгөөд Алтан Сум алтны хэтийн төлөв бүхий талбайтай баруун хойд зүгт залгаа оршдог. Суваг малталт болон чулуулгийн дээжийн судалгаагаар Хар Морь талбайд маш өндөр агуулга бүхий үр дүнгүүд илэрсэн. Алтан сум талбайн өмнө зүгт туслах структурын (Хар Морь талбайгаас 300 метрт орших) дагуу хийсэн өрөмдлөгөөр өнөөг хүртэл хамгийн өндөр үр дүн буюу газрын гадаргаас 75 метрийн гүнд 24 г/т-70 г/т алтны агуулга бүхий 2 метрийн интервал огтолсон. Хар Морь талбайд өрөмдсөн 11 цооногийн үр дүн хүлээгдэж байна. Дээрх хайгуулын цооногууд нь энэхүү томоохон хэмжээний талбайд 4-р улиралд хийх нэмэлт өрөмдлөгийн хөтөлбөрт багтах хамгийн өндөр хэтийн төлөв бүхий бүсүүдийг тодорхойлоход тусална.

Алтан Нар алт полиметаллын орд

Баян Хөндий алтны ордоос хойд зүгт 16 км-т оршдог Алтан Нар төсөл нь алт болон полиметаллын нөөцийг тэлэх өндөр боломжтой. Одоогийн Алтан Нар төслийн нөөц: Бодитой нөөц: 2.0 г/т алтны агуулга бүхий 318,000 унц алт, Боломжтой нөөц: 1.7 г/т алтны агуулга бүхий 186,000 унц алт болон мөнгө, бусад суурь металл багтаж байна. Хоёрдугаар үе шатны өрөмдлөгийн хөтөлбөрөөр энэхүү өндөр хэтийн төлөв бүхий талбайд шинээр нээлт илрүүлэх болон нөөцийг тэлэх судалгаа хийгдэнэ.

COVID-19 цар тахлаас урьдчилан сэргийлэхээр хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд:

2020 оны хайгуулын улиралд, компани нь аюулгүй, үр дүнтэй хайгуулын хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд COVID-19 вирусний тархалтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг нэмэгдүүлэн ажилласан. Компани нь COVID-19 вирусний тархалтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүд үргэлжлүүлэн хэрэгжүүлж, хээрийн ажлын хүрээнд гараа тогтмол угаах, байнгын ариутгал цэвэрлэгээ хийх зэргээр агааржуулалт,

ариутгал, халдваргүйжүүлэлтийн арга хэмжээг авч хэрэгжүүлэн, ажилтнуудаа халдвараас сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна. Өдөр тутам сэрэмжлүүлэг, зөвлөмжийг өгч, танилцуулга хийн, зочин хүлээн авах журмыг шинэчилж, биеийн халууныг шалгах ажлыг тогтмолжууллаа. Шаардлагатай нөхцөлд ашиглах зорилгоор тусгаарлах байр, хувийн хамгаалалтын хэрэгслүүдийг бэлтгэсэн. Нэгдүгээр сараас эхлэн Монгол Улсын засгийн газар олон улсад зорчих иргэдийн хөдөлгөөнийг хязгаарлах, бүх шатны хичээл сургалтын үйл ажиллагааг хязгаарлах, олон нийтийг хамарсан үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоох зэргээр иргэдээ вирусээс хамгаалах арга хэмжээг үр дүнтэйгээр хэрэгжүүлж байна. 2020 оны 8 сарын 31 хүртэл одоогийн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх шийдвэр гарсан. 2020 оны 8 сарын 18-ны байдлаар Монгол Улсад дотооддоо вирусний тархалт болон нас баралт бүртгэгдээгүй. Нийт батлагдсан болон тайлагнасан халдварууд нь олон улсын зорчих хөдөлгөөнөөс үүдсэн.

Хөндий Алтны Дүүргийн тухай

Эрдэнэ Ресурсийн ордууд нь дэлхийн томоохон алт, алт-зэсийн ордуудыг агуулагч Төв Азийн Орогены бүсэд багтдаг Эдрэнгийн террейнд байрладаг. Эрдэнэ Ресурс нь Монгол Улсын баруун өмнөд хэсэгт 10 гаруй жил хайгуул судалгааг хийн, өдгөө Хөндий алтны дүүргийг нээн илрүүлээд байна. Хөндий алтны дүүрэг нь өндөр агуулга бүхий алт, полиметаллын хэд хэдэн хэтийн төлөвт талбайг хамардгаас хоорондоо 16 км зайд орших Баян Хөндий, Алтан Нар ордуудыг ашиглалтын шатанд хүртэл хөгжүүлэхээр зорьж байна. Эдгээр ордуудыг хамтад нь Хөндий Алтны Төсөл (“Төсөл”) хэмээн нэрлэдэг.

Баян Хөндийд 3.16 г/т дундаж алтны агуулга бүхий 521,000 унц баттай болон бодитой геологийн нөөц³ (“Measured and Indicated Resources”)⁴, 3.68 г/т алтны агуулга бүхий 103,000 унц боломжит нөөц (“Inferred Resources”) тодорхойлогдсон. Баттай болон Бодитой нөөцөд 3.7г/т алтны агуулга бүхий 409,000 унц батлагдсан болон магадалсан үйлдвэрлэлийн нөөц (“Proven and Probable Reserve”) багтаж байна. (Хэвлэлийн мэдээтэй эндээс танилцана уу) Баттай болон бодитой нөөц, боломжит нөөцийг нэмэгдүүлж, үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэх боломжтой.

2020 оны 7 сард Эрдэнэ Ресурс нь Баян Хөндий Алтны Төслийн хараат бус нарийвчилсан ТЭЗҮ-ийн үр дүнг танилцуулсан. (Хэвлэлийн мэдээтэй [эндээс](#) танилцана уу) Нарийвчилсан ТЭЗҮ-ийн суурь үзүүлэлтээр татварын дараах өнөөгийн цэвэр үнэ цэн (5% хорогдуулалт бүхий) (NPV5%) \$100 сая ам.доллар ба дотоод өгөөжийн түвшин (IRR) 42% тооцоологдсон. Баян Хөндийн нарийвчилсан ТЭЗҮ нь 0-7 жилийн хугацаанд 3.71 г/т алтны дундаж агуулга бүхий, жилд 63,500 унц алт олборлохоор тооцоолсон бөгөөд уламжлалт нүүрстэй уусгах технологиор алтыг ялган авахаар төлөвлөсөн. Төслийн төлөвлөгөөгөөр олборлолтыг 2022 онд эхлүүлнэ.

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол Улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад Улсад бүртгэлтэй хайгуулын компани юм. Компани нь Монгол Улсын баруун урд бүсэд хайгуул хийх эрх бүхий 2 хайгуулын, 3 ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд эдгээр хайгуулын бүсэд хийсэн судалгааны үр дүнд Хөндий Алтны Дүүргийг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонто болон Монголын хөрөнгийн биржүүд дээр бүртгэлтэй. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг Компанийн вебсайт www.erdene.com -оос авч танилцах боломжтой. Компанийн талаарх чухал мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайтаар дамжин хүрдэг тул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан бодит мэдээлэл авахыг зөвлөж байна.

Мэргэшсэн этгээд (геологич) ба дээжлэлтийн протокол

Петер Далтон (Peter Dalton) нь Компанийн ахлах геологич (P.Geol., Nova Scotia) бөгөөд NI 43-101-т заасан мэргэшсэн этгээд ба урьдчилсан ТЭЗҮ, АШЭЗТ-оос бусад техникийн мэдээлэл, Баян Хөндийн эрдсийн баялаг, нөөцөөс бусад мэдээ мэдээллийг Эрдэнэ Ресурсийн зүгээс хянан баталгаажуулсан болно. Бүх дээжийг

³ Хөндий алтны төслийн эрдсийн нөөцийн дэлгэрэнгүй мэдээлэлтэй 2019 оны 12 сарын 4-нд SEDAR-т байршуулсан Тетра Текийн боловсруулсан NI 43-101 техникийн тайлангаас танилцана уу.

⁴ Баттай ба бодит геологийн нөөц: 3.77 г/т алтны агуулга бүхий 171,000 унц баттай нөөц, 2.93 г/т алтны агуулга бүхий 349,700 унц бодит нөөц

Улаанбаатар хот дахь Эс Жи Эс (“SGS”) лабораторид шинжлүүлсэн. Эс Жи Эс лабораторийн дотоод хяналт шалгалтаас гадна, Компани нь тусгай стандарт бэлдэц, хээрийн болон лабораторийн хуулбар, мөн хүдэржилтгүй бэлдцийг ашиглан дээжийн чанарын хяналт, баталгаажуулалт (“QA/QC”)-ын протоколыг гүйцэтгэсэн. Бүх дээжид алтны агуулгыг стандарт Хайлуулах аргаар (fire assay), бусад 33 химийн элементийг Индукцын хос плазмет спектрометрийн арга (Inductively Coupled Plasma Optical Emission Spectroscopy) ашиглан тогтоосон. 5 г/т алтны агуулгаас дээш агуулга илэрсэн дээжүүдэд алтны шигшүүрийн шинжилгээ (screenmetallic gold analysis) хийсэн ба энэ нь 500 г дээжний 75 микроноос бага байх 30 г бүхий 3 дээж болон 75 микроноос том байх хэсгүүдэд хийгдсэн алтны хайлуулах (fire assay) шинжилгээнүүдийн жигнэсэн дунджаар илэрхийлэгддэг.

Эрдэнийн дээжлэлтийн протокол нь (хүдэржилт болон чулуулгийн төрлөөс хамаарч) зарим нэг жижиг, хүдэржилтийн дараа үеийн чулуулаг болон хүдэржилтгүй боржинг алгассан, 1 эсвэл 2 метрийн интервалтайгаар, цооногийг бүтнээр нь хамарсан дээжлэлтээс бүрддэг. Дээжлэлтийн интервалыг чөмгөн дээжний гүний метр дээр үндэслэдэг ба геологийн хяналт эсвэл хүдэржилтээс хамаардаггүй болно. Бүх дээжийг чөмгөн дээжний гүний метр дээр үндэслэн алмазан хөрөөгөөр 2 тэнцүү хуваадаг. Хуваагдсан дээжийн талыг дээжний уутанд ялган авч дээжилдэг бөгөөд үлдсэн талыг нь дээжний хайрцганд үлдээн Компанийн Баян Хөндий дэх хээрийн ангид аюулгүй байдлыг ханган хадгалдаг. Бүх дээжийг нэг багцандаа 30 дээж байхаар хуваарилдаг ба багц болгонд стандарт бэлдэц, хүдэржилтгүй бэлдэц, лабораторийн хуулбар болон хээрийн хуулбар дээж буюу дээжийг 4 хуваан, 2-ыг нь 2 тусад нь дээжлэн хийж Улаанбаатар дахь Эс Жи Эс (“SGS”) лаборатори руу шууд тээвэрлэдэг. Тээвэрлэлтийг Эрдэнийн ложистикийн гэрээт компани Монруд ХХК гүйцэтгэдэг.

Урьдчилсан таамаглал

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш юм. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.

Энэхүү хэвлэлийн мэдээ нь англи хэл дээр бэлтгэгдсэн хэвлэлийн мэдээний орчуулга болно. Англи, монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх зүйл гарвал англи хэл дээрх хувийг мөрдөнө.

ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.

Холбоо барих:

Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон Гүйцэтгэх захирал

Роберт Женкинс, Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419

Twitter: <https://twitter.com/ErdeneRes>


Facebook: <https://www.facebook.com/ErdeneResource>

LinkedIn: <https://www.linkedin.com/company/erdene-resource-development-corp/>

YouTube: <https://www.youtube.com/channel/UCILs5s9j3SLmya9vo2-KXoA>

Bayan Khundii

Extension and Exploration Zones Q3-2020 Drilling Update



KHUNDII GOLD DISTRICT

Three deposits, multiple greenfield discoveries, limited exploration

Fast tracking to production

Altan Nar Deposit (Au, Ag, Zn, Pb)

Nomin Tal

Road to Shinejinst

Proposed Haulroad

Oyut Khundii

Altan Arrow

Khar Mori

Khundii North

Ulaan

Bayan Khundii Deposit (Au)

Khuvyn Khar

Zuun Mod Deposit (Cu, Mo)

